

## УЛСЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИУД

Өндөр мэдрэмжтэй багаж, тоног төхөөрөмж, сайн чанарын урвалж бодис, бэлтгэгдсэн чадварлаг боловсон хүчин бүхий сайн лабораторийг байгуулсанаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон хяналт оношлогоог тоон ба чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх боломжтой юм. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудыг зорилго чиглэлээс нь хамааруулан ***Судалгаа шинжилгээний шинж чанартай*** болон ***Техно-химийн шинж чанартай хяналтын лабораториуд*** гэж хоёр хувааж болно. Лабораториудын ихэнхи нь аймаг орон нутгийн болон албан байгууллагын харъяанд, байгууллагынхаа үйл ажиллагааны хүрээнд чиглэл чиглэлээрээ ажиллаж байна. Улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн томоохон лабораториуд нь багаж тоног төхөөрөмж, эм урвалжийн хангамж, боловсон хүчний нөөц бололцоо харьцангуй сайн юм.

Судалгаа шинжилгээний шинж чанартай лабораториудын тоонд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их сургуулиудын эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг лабораториуд орно. Эдгээр лабораториудын үйл ажиллагаа нь шинжилгээ, судалгааны ажлын зорилго, чиглэлээсээ хамааран өөр өөр байх боловч ажлаа өндөр түвшинд хийж гүйцэтгэж чадахуйц сайн тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангагдсан байх нь зүйтэй юм.

Техно-химийн шинж чанартай хяналтын лабораториуд нь түүхий эд, бараа бүтээгдэхүүнд болон байгаль орчинд задлан шинжилгээ хийж, хяналт шалгалт тавьдаг, хүн, малын өвчний оношлогоо хийж үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн хяналт, стандарт хэмжил зүй, эмнэлэг, үйлдвэр, компанийн лабораториуд орно. Эдгээр лабораториудад хүнс, ундны ус, эрдсийн түүхий эд, нефть бүтээгдэхүүн, барилгын материал, мал амьтны гаралтай түүхий эд зэрэг эх орны болон импортоор орж ирж байгаа бүх төрлийн түүхий эд, бараа бүтээгдэхүүнд, байгаль орчин болох ус, агаар, хөрсөнд задлан шинжилгээ, хүн, малын өвчний оношлогоо хийж улс орон, аймаг орон нутаг, харъяалагдаж буй байгууллагадаа үйлчилгээ үзүүлдэг болно.

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв нь (СХҮТ) Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг хяналт, сорилтын лабораториудыг итгэмжлэлд хамруулж тодорхой хугацаагаар эрх өгч ажиллуулж байгаа билээ. Мөн Монголын Худалдаа, Аж Үйлдвэрийн Тэнхимийн (МХАҮТ) дэргэд итгэмжлэгдсэн лабораториудын үйл ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Итгэмжлэгдсэн лабораториудын зөвлөл” –ийг 2006 онд байгуулж ажиллуулж байна.

Улсын хэмжээний судалгаа, шинжилгээний лабораториудын нөхцөл байдал өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа учраас эрдэм шинжилгээ, судалгаа, оношлогоо, хяналт, үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг бүх төрлийн лабораториудын үйл ажиллагааг дээшлүүдэхэд (i) материаллаг бааз, мэдлэгтэй боловсон хүчнээр хангах, (ii) хөрөнгө оруулалтыг улсын хэмжээнд лабораториуд хоорондын уялдуулдаг зохицуулж, эрэмбэлж дэс дараалан хийх, (iii) мэргэжлийн боловсон хүчнийг мэргэшүүлэх, лабораторийн тоног төхөөрөмжүүдэд ямар нэгэн доголдол, гэмтэл гарахад түүнийг засах, тохируулах мэргэжилтнүүд

бэлтгэх, (iv) лабораториудад хэрэглэж байгаа урвалж бодис, арга аргачлалыг стандартжуулах. Ижил төстэй чиглэлээр ажилладаг лабораториудад хийгдэж байгаа адилхан шинжилгээний дүн өөр өөр гарахад нөлөөлж буй хүчин зүйлс нь хийж байгаа арга, ашиглаж байгаа эм, урвалж, багаж тоног төхөөрөмж, боловсон хүчний мэдлэг чадвар, ур дүй зэргээс хамаарч байгаа юм.

УЛСЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЛАБОРАТОРИУД

№		ЛАБОРАТОРИЙН НЭР	ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ЧАДАМЖ
1	БОТАНИКИЙН ХҮРЭЭЛЭН	Ботаникийн хүрээлэнгийн ургамалын биотехнологийн лаборатори	Монгол орны ховор болон нэн ховор ургамалыг эд эсийн өсгөврийн аргаар үржүүлэх, тарималжуулах.	Ховор, устаж үгүй болж буй байгаль дээр үрээр ургах чадамж муутай ургамлыг үржүүлгийн аргаар үржүүлж, генобанкийг биотехнологийн аргаар хадгалж хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх судалгааг хийнэ.
2		Ботаникийн хүрээлэнгийн ургамалын фитохимийн лаборатори	Ургамлын хими, биохимийн судалгааны бааз суурийг сайжруулж, дэлхийн түвшинд ойтсон судалгаа явуулах.	Ашигт ургамалын биологийн идэвхит нэгдлийн судалгаа, бэлчээрийн ургамлын тэжээллэг чанарын судалгааг хийдэг бөгөөд ургамлын хөгжлийн үе шат, эрхтэн хэсгээс хамаарсан динамик судалгаа явуулна.
3		Ботаникийн хүрээлэнгийн Гербарийн сан /UBA/	Монгол улсын өмч, Ургамлын сан (UBA) ургамлын зүйлийн биет цуглуулгыг байгалийн бүс, бүслүүрийн бүх цэгүүдээс бүрэн цуглуулж, хойч үедээ шинжлэх ухааны хосгүй үнэтэй сан хөмрөгийг өвлүүлэн, шинжлэх ухааны үйлсэд зориулах гол зорилготой.	Эдүгээ энэ ургамлын сан нийт 123.000 гаруй хувь цуглуулгатай бөгөөд үүнд 110 гаруй овгийн 640 гаруй төрөлд багтах 2800 орчим зүйлийн гуурст дээд ургамлын 80.000 гаруй хувь цуглуулга бүртгэгдсэн. Монгол орны ургамалын аймгийн нийт зүйлийн бүрдлийн 95 хувийг эзэлж байна.
4	ГАЗАРЗҮЙН ХҮРЭЭЛЭН	Газарзүйн хүрээлэнгийн Цэвдэг судлалын лаборатори	Мөнх цэвдгийн газарзүйн тархалтын ерөнхий зүй тогтол, хөгжлийн түүх, түүний хувьсал өөрчлөлтийг судалж үнэлгээ, прогноз өгч, түүнийг практикт ашиглах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах.	Монгол орны хэмжээнд нийт 100 орчим цооногт тодорхой гүнүүдэд температурын хэмжилтийг <i>DATALOGGER U12</i> төрлийн багажаар хэмжиж судалгааны анхны мэдээ материал цуглуулж мөн тодорхой цэг талбайд криогени үйл явц үзэгдлийн судалгаа хийж байна.
5		Газарзүйн хүрээлэнгийн ГЗМС-ийн лаборатори	Өмнөх үеийн судалгааны үр дүн болон хиймэл дагуулаас авсан гэрэл зургийг ашиглан орчин үеийн шинэ техник, программ хангамжаар боловсруулж бүх шатны хэрэглэгчдийн шаардлагыг хангасан газарзүйн мэдээллийн систем бий болгох сэдэвчилсэн зургууд зохиох үндсэн зорилготой.	Бүх төрлийн сэдэвчилсэн зураг, атласыг зохиох боломжтой.
6		Газарзүйн хүрээлэнгийн хөрс судлалын лаборатори	Монгол орны хөрсөн бүрхэвчийн ангилал, зураглал, эвдрэл, бохирдол, хими, ус-физик шинж, хөрсийг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр судалгаа явуулах.	Хөрсний хими-агрохими, ус-физик шинжийн 40-өөд нэр төрлийн задлан шинжилгээ хийдэг.

7	<b>ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН</b>	Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний экологийн лаборатори	Газрын доройтол, цөлжилтийн нөлөөгөөр хөрсний чанарт гарч байгаа өөрчлөлтийг судлах	Шинэ байгуулагдсан
8		Геоэкологийн хүрээлэнгийн биоэкологийн лаборатори	Монгол орны нуур, голуудаас усны амьтдыг цуглуулан экологийн төлөв байдалд үнэлгээ өгөх, бохирдол доройтлоос хамгаалах, лабораторийн нөхцөлд тэдгээрийг өсгөн үржүүлж туршилт судалгаа явуулах, улсын хэмжээнд усны амьтдын мэдээллийн санг бүрдүүлэх.	Биологи-экологийн чиглэлээр сурч буй оюутан сурагчдыг дагалдан сургах боломжтой.
9		Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лаборатори	Монгол орны нийт нутаг дэвсгэрийн газар доорхи болон гадаргын усны чанар, найрлага, бохирдлын үзүүлэлтүүдийг шинжлэн судлах.	Усны дээжинд шинжилгээ хийж, усны хэрэгцээ, зориулалтаас нь хамааруулан стандартуудтай харьцуулан үнэлэлт, дүгнэлт гаргана.
10	<b>ХИМИ, ХИМИ-ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН</b>	ХХТХ-ийн Эрдэс судлал гидрохимийн лаборатори	Эх орны эрдэст нуурууд, унд ба рашаан усны химийн найрлага, гидрогеологийн нөхцөл, ашиглалтын технологийн судалгаа. Цахиурт нэгдлийн (наанги шавар, цеолит, нефелин) физик хими, эрдэс бүрэлдэхүүн болон хэрэглээний судалгаа.	
11		ХХТХ, “Нүүрсний хими, технологийн лаборатори”	Нүүрс, шатдаг занарын гарал үүсэл, метаморфизм ба шинж чанарын хоорондын хамаарал, ангилалыг судлах. Нүүрсний пиролиз, чанарыг сайжруулах, хийжүүлэх болон шингэрүүлэх технологи, хатуу түлшнээс кокс, утаагүй түлш, шүүгч, шингээгч материал, бордоо, эмийн бэлдмэл гарган авах арга, технологи, боловсруулах, реактор зохион бүтээх.	
12		ХХТХ, “Материал судлал, технологийн лаборатори”	Механо-химийн аргаар эрдэс хүдрийг боловсруулж, бүтцийн өөрчлөлтийг судлан эрдсийн уусалтыг нь сайжруулах, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх. Экологийн цэвэр бордоо гарган авах судалгаа ба цахилгаан станцын хаягдал үнсийг дахин боловсруулж шинэ төрлийн дэвшилтэт	Эрдэс хүдрийн химийн болон эрдсийн найрлагыг тодорхойлно. Бүх төрлийн эрдэс бордооны найрлагыг тодорхойлж, чанарын үнэлгээ өгнө. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, үнэлгээ өгнө. Шинэ материал, наноматериал, барилгын материалын судалгаа, үйлдвэрлэлийн туршилтыг захиалгаар хийж гүйцэтгэх, зөвлөгөө өгөх

			материал болон геополимер-барилгын материал гарган авах судалгаа.	
13		ХХТХ, Үнэт, ховор металлын аналитик хими, технологийн лаборатори	Үнэт, ховор металлын хүдэр, эрдэс, баяжмалыг уусгах, ионуудыг ялгаж авах ба тэдгээрийг шингээх шинж чанарын судалгаа, шинэ төрлийн флотурвалж гарган авах, баяжуулах идэвхийн судалгааг хийх	Эрдэс түүхий эд, үйлдвэрийн хаягдал дахь үнэт, ховор металлын агуулга, тэдгээрийн нэгдлийн хэлбэрийг химийн аргаар тодорхойлно. Үйлдвэрийн хаягдал усан дахь хүнд хортой элементүүд болон цианидын агуулга, органик бус бодисыг таньж, чанар, агуулгыг тодорхойлно.
14	ХИМИ, ХИМИ-ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	ХХТХ-ийн Байгалийн нэгдлийн химийн лаборатори	Эмийн ургамлын биологийн идэвхт бодисуудын цэвэр төлөв байдлаар ялган авах, молекулын бүтэц байгууламжийг физик химийн аргуудаар нарийвчлан судлан тогтоох. - Эмийн ургамлын биологийн идэвхт бодисуудын биологи, фармакологийн идэвхи үйлдлийг судлах, шинэ эм бэлдмэл буй болгох.	
15		ХХТХ-ийн Органик химийн лаборатори	Монгол орны нефть, битумт элс, шатдаг занарын хими, хими-технологийн судалгаа ба эмчилгээний шаврын химийн найрлага, биологийн идэвхийг судлах.	Нефть, нефтийн фракцууд болон товарын нефть бүтээгдэхүүний шинж чанар, нүүрс устөрөгчдийн найрлага, биомаркер нэгдлүүдийн нэр төрөл, агууламжийг тодорхойлно. Битумт элс, шатдаг занарын химийн найрлага, шинж чанар, эмчилгээний шаврын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно.
16		ХХТХ-ийн Органик химийн лаборатори	Монгол орны нефть, битумт элс, шатдаг занарын хими, хими-технологийн судалгаа ба эмчилгээний шаврын химийн найрлага, биологийн идэвхийг судлах.	Нефть, нефтийн фракцууд болон товарын нефть бүтээгдэхүүний шинж чанар, нүүрс устөрөгчдийн найрлага, биомаркер нэгдлүүдийн нэр төрөл, агууламжийг тодорхойлно. Битумт элс, шатдаг занарын химийн найрлага, шинж чанар, эмчилгээний шаврын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно.
17		ХХТХ-ийн Биохими-технологийн лаборатори	Монгол орны амьтан, ургамал, бичил биетний гаралтай түүхий эдийн биологийн идэвхтэй нэгдэл: уураг, нүүрс ус, липидийн химийн шинж чанар, бүтэц байгууламжийг судлах.	Амьтан, ургамал, бичил биетний гаралтай түүхий эдийг иж бүрэн боловсруулан хүнс, анагаах ухаан, хөнгөн үйлдвэрт ач холбогдолтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулна.

18	БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	Биологийн хүрээлэн, ургамлын биотехнологи	Ховор, ховордож устаж буй ашигт, өвслөг болон модлог ургамлыг өсгөвөрлөх, хүлэмж, ил талбайд шилжүүлэх, эдийн өсгөвөр байдлаар генофондыг хадгалах, эмийн ургамлын нөөцийг нэмэгдүүлэх, ашигт бодисын судалгааг эс, эдийн түвшинд хийх боломжийг тогтоох, вирус, бактерийн өвчнөөс эрүүлжүүлсэн суулгац гаргаж авах.	Орчин үеийн ургамлын биотехнологийн талаар бодит мэдээллийг олон нийтэд түгээх, оюутан сурагчдын үйлдвэрлэлийн дадлага, бакалавр, докторын дипломын ажил хийлгэх бүрэн боломжтой.
19		Биологийн хүрээлэн Молекул биологийн лаборатори	Молекул биологийн судалгааг дэлхий дахины судалгааны чиг хандлага, жишигт хүргэх зорилт тавьж, биологийн процессуудын молекул механизмыг танин мэдэх, хүний эрүүл мэнд, мал, ургамлын ашиг шимийг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, биоаюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн суурь болон хавсрага судалгаа явуулах.	Тус лаборатори нь молекул биологийн судалгаа, шинжилгээ хийдэг бөгөөд бусад хүрээлэн, их сургуулиудтай нягт хамтран ажилладаг.
20		Биологийн хүрээлэн Генетикийн лаборатори	Монгол мал, монгол орны ховор болон нэн ховордсон амьтны генетик статусыг тодорхойлох, өсгөн үржүүлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах.	Орчин үеийн генетикийн талаар бодит мэдээллийг олон нийтэд түгээх.
21		Биологийн хүрээлэн Микробын нийлэгжлийн лаборатори, биоцех	Замаг, бактерийн омгийг ашиглаж биобэлдмэл гарган авах технологи боловсруулах, хүнс, тэжээлийн нөөц тэжээл, байгаль орчны бохирдлыг бууруулах, үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх, хүнсний бүтээгдэхүүн бохирдуулагч бичил биетний эсрэг үйлчлэлтэй эфирийн тосыг ашиглан бүтээгдэхүүний чанар, хадгалалтыг сайжруулах зорилготой.	Олон жилийн судалгааны үр дүнд бий болсон биологийн өндөр идэвхтэй үйдвэрлэлийн омгийг судалгаа, үйлдвэрлэл, сургалтын ажилд ашиглаж, биобэлдмэл гаргах технологи боловсруулж, бүтээгдэхүүнийг хүнс, анагаах ухаан, хөдөө аж ахуйн салбарт ашиглаж, микробиологийн салбарын үр өгөөжийг дээшлүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс хамгаалах үйлчилгээтэй.
22		Биологийн хүрээлэн Микробиологийн лаборатори	Монгол орны бичил биетний олон янз байдал, генетик нөөц, биологийн идэвхийг судлах.	Биологийн олон янз байдлын чухал хэсэг болох бичил биетний экологи, эдийн засгийн ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах, хөрсний эрүүл ахуйн байдал ба үржил шимийг микробиологийн аргаар тодорхойлох.

23	БОТАНИКИЙН ХҮРЭЭЛЭН	Ботаникийн хүрээлэнийн Ургамлын анатоми-физиологийн лаборатори	Монгол орны нэн ховор, ховор, бэлчээрийн ашигт зарим ургамлын усан солилцооны онцлогийг илэрүүлэх	Ургамлын усан солилцоо цаашлаад ган тэсвэр болон халуун, дулаан тэсвэр, навчны амсрын хөдөлгөөн зэрэг үзүүлэлтүүдийг үзэхэд зарим багаж тоног төхөөрөмж, урвалж хомс байна. Бусад хүрээлэнд ургамлын анатомийн судалгаа огт хийгддэггүй.
24		Ботаникийн хүрээлэнгийн Мөөгний лаборатори	Байгалийн мөөгийн амьд өсгөвөрийн санг баяжуулах, ховор, нэн ховор мөөгүүдийн генофондыг хамгаалах зорилготой.	Монгол оронд байгалийн мөөгийн цуглуулгын сан зөвхөн энд хадгалагдаж байдаг. Хатаасан цуглуулгын санд байгаа мөөгийг нягтлан боловсруулалт хийхэд шаардлага хангадаггүй тул олон улсын жишгийн дагуу ховор мөөгүүдийн амьд сантай болж байгаа нь цаашид хийгдэх мөөгийн генетик, ангилалзүй, физиологи гэх мэт олон талын судалгаа явуулах эх материал бүрдэх юм.
25		АМГ, Уул уурхайн шинжилгээ туршилтын лаборатори	Төрөөс уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн хөгжилд эрдэс баялагийн салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх.	Хатуу түлшний техникийн иж бүрэн шинжилгээ: Чулуун ба хүрэн нүүрс, занар, хагас кокс, кокс, шахмал түлш г.м. хатуу түлшний чийг, үнс, хүхэрийн агуулга, дэгдэмхий бодисын гарц, илчлэг ба хатуу түлшний физик, механик болон коксжих, дулааны шинж чанарын шинжилгээ: нягт, гадаргуйн талбай, сүвэршилийн хэмжээ, үнсний хайлах температур, чөлөөт хөөлтийн зэрэг шинжилгээ хийх. Хатуу түлшийг баяжуулах, брикетлэх, утааны найрлага тодорхойлох туршилтууд, ашигт малтмалын бүтэц, найрлагын шинжилгээ, уул уурхайн орчны бохирдлын шинжилгээ, үнэлгээ: Хөрс ба усанд агуулагдах Хүнд ба ховор элементүүдийг тодорхойлж шинжлэх.
26		ЦҮОШГ, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори	Байгаль Орчны Шинжилгээний Төв Лаборатори /БОШТЛ/ нь Монгол орны хэмжээнд байгаль орчны чанарт хяналт тавих ажлыг гүйцэтгэдэг. Одоо байгаль орчны сүлжээнд орон нутгийн 21 лаборатори , орчны агаарын чанарыг хянах 35 суурин харуул, гадаргын усны чанарын хяналтын 13 нуур, 80 гол мөрний 150 цэг, хаягдал усны 20 гаруй цэвэрлэх байгууламжийн 40 орчим цэг, уналын /аэрозолын цацраг идэвхи/ сорьцын 23 цэг, цацраг идэвхийн орчны фондын 35 цэг, хөрсний чанарын хяналтын 390 цэг, хүчиллэг	Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд <ul style="list-style-type: none"> <li>• Орчны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр гаргах</li> <li>• Хяналт шинжилгээний сүлжээг арга зүйн удирдлагаар хангах</li> <li>• Орчны сорьцонд шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлэлт өгөх</li> <li>• Чанарын хяналт/чанарын баталгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх</li> <li>• Орчны чанарын стандартыг бий болгох шинэ аналитик аргуудыг судлаж нэвтрүүлэх</li> </ul>

27	НЭМҮТ-ийн лаборатори	<p>тунадасны хяналтын 2 цэг хамрагдаж байна.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лабораторийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь эрдэм шинжилгээний төсөлт ажлуудыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ хийж гүйцэтгэх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн лабораториудад мэргэжлийн зөвлөгөө өгөх.</p>	<p>Хүрээлэн буй орчны болон шим тэжээлийн гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 лабораторитойба үүнд: Шим тэжээл судлалын химийн лаборатори, Хүрээлэн буй орчин судлалын химийн лаборатори, Микробиологийн лаборатори болон Клиник химийн лаборатори орно.</p>
28	УМХГ-ын нэгдсэн төв лаборатори	<p>Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай хүнс, бараа бүтээгдэхүүн хэрэглэх нөхцлийг бүрдүүлэхэд тавих төрийн хяналт шалгалтын ажлын үр дүнг бие даасан, хараат бус магадлан шинжилгээний дүнгээр баталгаажуулан хангаж, лабораторийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх явдал юм.</p>	<p>Нэгдсэн төв лаборатори нь Монгол улсын хяналтын байгууллагуудын нэгдсэн анхны лаборатори бөгөөд импорт, экспорт, эх орны үйлдвэрийн бүх төрлийн хүнс, эм, ахуйн болон гоо сайхны бүтээгдэхүүн, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, хөрс, усанд хяналтын баталгаажуулах шинжилгээг хийх, аймаг, нийслэл, химийн боомтын лабораториудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тэргүүлэх үндсэн лаборатори юм.</p>
29	НМХГ-ын төв лаборатори	<p>Бүтцэнд эрүүл зүйн хими, хор судлалын лаборатори, эрүүл зүйн нян судлалын лаборатори гэсэн хоёр үндсэн том лаборатори, 14 нэгж лаборатори ажилладаг Багануур, Налайх дүүргүүдэд салбар лабораториудтай. Лабораторийн эрхэм зорилго нь хүн амын эрүүл мэндийг хамгаалахад хүнсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны бохирдол, хөдөлмөрлөх нөхцлийн хяналтын шинжлэх ухааны үндэс болсон лабораторийн хяналтын шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр технологээр хийж гүйцэтгэн, байгаль, нийгэм, орчноос хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болохуйц хими, физик, биологийн хүчин зүйлүүдийг илрүүлэн, нотолгоонд тулгуурласан, баталгаат хариугаар албыг болон иргэд, үйлчлүүлэгчдийг хангах явдал юм.</p>	<p>Стандартчилал, Хэмжил Зүйн Газрын итгэмжлэлд 1997 оноос хойш тасралтгүй 5 дах удаагаа хамрагдан, Итгэмжлэлийн хүрээний 73 ангиллын сорилтын шинжилгээг 703 үзүүлэлтээр хийдэг ба НМХГ-ын Төв лабораторийн нийт 200 орчим шинжилгээний стандарт арга аргачлалаас 61,5%-ийг MNS аргаар, 22,4%-ийг ISO аргаар, 12,5%-ийг бусад аргын стандартыг үндэслэн гүйцэтгэдэг. Мөн сорилт туршилтын шинжилгээний 74-н үзүүлэлтүүдийг орчин үеийн өндөр мэдрэг багажуудаар хийж гүйцэтгэж байна</p>



30	Улсын мал эмнэлэгийн ариун цэврийн төв лаборатори	Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлүүд, түүнчлэн ашигт малтмалын хайгуул, олборлолт, уул уурхайн үйлдвэрлэл түүнээс үүдэлтэй цөлжилт хуурайшилт, онош тодорхойгүй өвчин, эмгэгийн гаралт, тархалт нэмэгдэх хандлагатай байгаа нь малын эрүүл мэнд, улмаар хүнсний аюулгүй байдалд нөлөөлж байна.	Олон улсын атомын энергийн агентлагт (ОУАЭА), Монгол улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд “Малын өвчний оношлогоо, тандалт урьдчилан сэргийлэх шинжилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах” нэртэй техникийн хамтын ажиллагааны төслийг 2012-2014 онд хэрэгжүүлж байгаа ба энэ төслийн хүрээнд лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, өндөр хөгжилтэй орнуудын ижил төрлийн лабораториудад мэргэжилтэн сургах ажлыг авч хэрэгжүүлж байна.
31	УСУГ-ын Усны төв лаборатори	Байгууллагын цэвэр, бохир усны чанарт хяналт тавьдаг 2 лабораторийн үйл ажиллагааг нэгтгэх, дотоодын хяналтын лабораторийг тоног төхөөрөмж, чадамж, бие даасан талаас нь бэхжүүлэх зорилгоор Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй УБНААС–II төслийн хүрээнд орчин үеийн өндөр мэдрэмжит багаж, тоног төхөөрөмжөөр тоноглон, байгууллага өөрийн хөрөнгөөр иж бүрэн тохижуулж 2010 оноос УСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ нэртэйгээр шинэчлэн зохион байгуулсан.	Усны төв лаборатори нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараах 2 чиглэлээр дотоодын хяналт тавих үүрэгтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн хүн амыг хангаж буй цэвэр усны аюулгүй байдалд</li> <li>• Цэвэрлэх байгууламжид нийлүүлж байгаа болон цэвэрлэгдээд гарч байгаа усны бохирдолтын хэмжээ, цэвэршилтийн түвшинд</li> </ul> Түүнчлэн НААҮ-ний байгууллагуудын дотоодын хяналтын лабораторийн мэргэжилтнүүдэд зориулан химич, бактериологич, лаборант, шил сав угаагч, сорьц авагч зэрэг мэргэжлүүдээр сургалт зохион байгуулж, дотоодын хяналтыг хэрхэн тавих талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна.
32	Цөмийн Энергийн Газрын цацрагийн хяналтын шинжилгээ тохируулгын алба	Цацрагийн хяналт шинжилгээ, тохируулгын лабораторийн үндсэн зорилго нь хүний эрүүл мэнд болон байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөнд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хүн ам болон цацрагтай ажиллагчдад шууд болон шууд бусаар нөлөөлж буй ионжуулагч цацрагийн тунг хэмжилт, шинжилгээгээр тогтоон баталгаажуулах, ионжуулагч цацраг хэмжигч багаж төхөөрөмжүүдийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах.	Цацрагийн хяналт шинжилгээ, тохируулгын лабораторийн үндсэн чиглэл нь: Хүрээлэн буй орчны дээж болон боловсруулсан бүтээгдэхүүнд цацраг идэвхт изотопын хувийн идэвхийг тодорхойлох шинжилгээ хийх; Гадаад орчинд ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хяналтыг байнга хийх; Цацрагийн үүсгүүр ашиглан үйл ажиллагаа явуулдаг аж ахуй, нэгж байгууллагын орчинд ионжуулагч цацрагийн бохирдлын хэмжилт хийх; Рентген оношлогооны аппарат, тоног төхөөрөмжийн чанарын хяналтыг хангуулах хэмжилт хийх; Ионжуулагч цацрагийг бүртгэх, хэмжигч багаж төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг ханган ажиллах, Ионжуулагч цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунг үнэлэх, мэргэжлийн

			зөвөллөгөө өгөх чиг үүрэгтэй ажиллаж байна.
33	Нийслэлийн агаарын чанарын албаны хяналт үнэлгээний хэлтэс	Хөдөлгөөнт станц, хөдөлгөөнт эх үүсвэр, үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээ зэрэг бүх төрлийн агаар бохирдуулах эх үүсвэрт хэмжилт хийж, тархалтын загварчлалыг гүйцэтгэнэ.	
34	Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн дэргэдэх Зуухны туршилтын лаборатори	2010 онд ЭБЭХЯам болон донор түнш орнуудтай хамтран байгуулагдсан ба Монгол улсад анх удаа гэрийн зуухны туршилт хийдэг лаборатори юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхүүдийн зуухыг сайжруулсан зуухаар солих ЗГ—ын хөтөлбөрийг дэмжих үүх зээлд нийлүүлэгдэн буй зуухнуудыг туршиж улмаар протокол хийнэ.	Тус лаборатори нь сорил авах ба харьцуулсан тооцоо хийх, зуух үйлдвэрлэгчдэд шаталтын онол ба зуухны хийцээр практик сургалт явуулах. УБ хотын халаалтын зуухнуудаас ялгарах РМ-ын зөвшөөрөгдөх утгыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр өргөн хүрээнд турших, РМ ялгаралыг их хэмжээгээр бууруулах зуухны R&D загварыг ашиглах, MNS 5457:2005 стандартын шаардлага хангасан зуухыг үйлдвэрлэх.